



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 5/03

Улаанбаатар хот

Сургалтын зардал батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан төвийн дүрмийн 4.7.6, 4.7.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн албан хаагчдын гаргасан өргөдөл, хүсэлтийг үндэслэн мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрагдахад шаардагдах сургалтын зардалд дэмжлэг үзүүлэх албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Сургалтын зардалд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 39.403.158 /гучин есөн сая дөрвөн зуун гурван мянга нэг зуун тавин найм/-н төгрөгийг 2017 оны сургалтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Очир/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аж ахуйн албаны дарга /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Б. НАРАНТУЯА

